

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.02.17

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- ТОП-20 индекс оны эхнээс 5.4% өсөв.
- Инфляц улсын хэмжээнд өнгөрсөн 1-р сард 9.6%-д хүрлээ.
- Хаан Банк ХК нэгж хувьцаанд 195.35 төгрөгийн ногдол ашиг олгоно.
- Монложистик Холдинг ХК хувьцааны тодорхой хэсгээ эргүүлэн худалдан авна.

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	2.47%	2.05%	25.47%
MSE A	3.23%	1.95%	20.27%
MSE B	-1.44%	3.99%	34.89%
2025/02/10 – 2025/02/14			

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	1,472,284,528.00
NEH	633,980,009.42
GLMT	373,809,955.00
INV	345,283,960.00
MSE	249,981,110.42
2025/02/10 – 2025/02/14	

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
SOR	3,636.00	32.22%
NEH	27.78	22.65%
HBZ	7,935.00	15.00%
MVO	1,266.00	14.99%
DHU	2,380.00	14.98%
2025/02/10 – 2025/02/14		

2025 он 02-р сарын 17

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,733

ТОП-20 индекс

54,122

MSE A

21,188

MSE B

15,498



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.0%

2024-III улирал

Инфляц

9.6%

2025-01 сар

ГВУН(сая\$)

4,884.28

2025-01 сар

Бодлогын

хүү

10.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.92%

USD/MNT

3,459.07

2025-02-16



Дотоодын зах зээлийн мэдээлэл

АПУ ХК НЭГЖ ХУВЬЦААНД 65 ТӨГРӨГИЙН НОГДОЛ АШИГ ОЛГОНО


“АПУ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 2-р сарын 10-ны өдрийн 25/02 тоот тогтоолоор компанийн 2024 оны хоёрдугаар хагас жилийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Энэ удаагийн шийдвэрийн дагуу нэгж хувьцаанд 65 төгрөгийн ногдол ашиг олгож, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ) ХХК-иар дамжуулан 2025 оны 8 сарын 19-ний дотор хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулна. Тус компани өмнө нь 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 55 төгрөгийн ногдол ашиг хуваарилсан билээ.

ХААН БАНК ХК НЭГЖ ХУВЬЦААНД 195.35 ТӨГРӨГИЙН НОГДОЛ АШИГ ОЛГОНО

Хаан Банк 2024 оны цэвэр ашгаас нийт 373.55 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд нэгж хувьцаанд 195.35 төгрөг (татварын өмнөх) оногдох юм. 2025 оны 2-р сарын 13-ны өдрийн хаалтын ханш болох 1,213 төгрөгөөр тооцоход нэгж хувьцааны ногдол ашгийн өгөөж 16.1% байна.


Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өдрөөр тогтоох бөгөөд уг жагсаалтад багтсан хувьцаа эзэмшигчид ногдол ашиг авах эрхтэй болно..



2025 он гарснаар хувьцааны ханш 12.9 хувиар өсжээ.

МОНГОЛ УЛСЫН ИНФЛЯЦ 2025 ОНЫ 01 САРД 9.6 ХУВЬД ХҮРЧ ӨСӨВ

2025 оны 1 сард улсын хэмжээнд хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 9.6 хувь, өмнөх сараас 1.4 хувиар өссөн байна. Тодруулбал, инфляцын өсөлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 нэгж хувиар нэмэгджээ.



Инфляцын өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйлс:

- Импортын барааны үнэ (бензин, түлшнээс бусад) 30.6%-иар өссөн
- Дотоодын барааны үнэ (мах, хатуу түлшнээс бусад) 53.2%-иар өссөн

Эх сурвалж. Монгол Банк, Монголын Хөрөнгийн Бирж



ТОП-20 индекст багтах компаниудын 2024 оны жилийн эцсийн тайлан

2024 оны шинэчилсэн ТОП-20 индексийн багцад өмнөхөөс 17 компани хэвээр үлдэж, харин "Сэндли ББСБ" ХК, "Монос хүнс" ХК, "Газар шим үйлдвэр" ХК хасагджээ. Тэдний оронд "Хас банк" ХК, "Ард санхүүгийн нэгдэл" ХК, "Лэндмн ББСБ" ХК шинээр багтан, индексийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороод байгаа билээ. Тэгвэл ТОП-20 индекст багтах компаниуд санхүүгийн аудитлагдаагүй тайлангаа танилцуулсаар байна.

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН



- Тээврийн салбарын нийт орлого – 7 их наяд төгрөг, өсөлт +7%
- Монложистикс Группийн орлого – 297 тэрбум төгрөг, өсөлт +41.2%
- Нийт ачаа тээврийн эргэлт – 128.8 сая тонн, өсөлт +21%
- Экспортын ачаа тээвэр – 97.0 сая тонн, өсөлт +19%

Хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор компани зах зээлээс тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авна.

- Эргүүлэн худалдан авах хувьцааны дээд хэмжээ – 4.8 сая ш
- Худалдан авах дээд үнэ – 210 төгрөг
- Нийт төсөв – 1.008 тэрбум төгрөг хүртэл

Үзүүлэлт

P/E TTM	3.72
P/B	1.6
EPS	5.4₮
33Y	76.8 тэрбум ₮

График 1. Борлуулалтын орлого (тэрбум төгрөг)




График 2. Цэвэр ашиг (тэрбум төгрөг)






График 3. МУ-ын тээврийн салбарын орлого (тэрбум төгрөг)



ТОП-20 ИНДЕКСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СОНГОЛТ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?

График 4. МХБ-ын ТОП-20 индекст багтах компаниудын ногдол ашгийн өгөөж (2024Y2)





График 5. МХБ-ын ТОП-20 индекст багтах компаниудын үнэлгээний матриц (2024Y2)



*Үнэ-ашгийн харьцаа (P/E) нь компанийн үнэлгээ зах зээлийн хүлээлттэй хэр нийцэж байгааг харуулдаг бол ногдол ашгийн өгөөж (DY) нь хөрөнгө оруулагчдад шууд орлогын эх үүсвэр болдог. Иймд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа P/E болон DY-ийн тэнцвэрийг харгалзан үзэх нь зах зээлийн эрсдэлийг удирдаж, өгөөжийг оновчтой болгоход чухал ач холбогдолтой.